Уг барилга цахилгаан хангамжийн найдваржилтийн 2-р зэрэгт багтана. Цахилгаан сүлжээний байгуулалтыг БД43-101-03 цахилгаан байгууламжийн дүрмэнд заасан шаардлагуудын дагуу эзс голтой утас, кабелиар гүйцэтгэнэ. 3 фазын хэрэглэгчдийг 5- утаст системээр нойлийн утас нь фазын утастай ижил голчтой 5-утаст дамжуулагчаар тэжээнэ.Хамгаалалтын / PE/ дамжуулагчийн хөндлөн огтлолын фазын утас 16 мм2 хүртэл ижил , түүнээс дээш бол фазын утасны хөндлөн огтлолын 50%-тай тэнцүү байхаар сонгоно. ЕС-1 хуваарилах самбарт тоног төхөөрөмжийн ажиллах зарчим : Дулаан хангамжийн болон усан хангамжийн насосуудыг инверьтерээр дамжуулан тэжээнэ. Цахилгаан хаалтуудын УС-1, самбараас тэжээнэ.Цахилгаан хаалтуудын фаз тэнцүүлэн хуваарилан тэжээсэн да КИПиА зурагт тусгагдсан болно. Системийг хянах СКАДА систем бүхий HMI дэлгэцтэй хяналт удирдлагын төв самбар, мэдрэгч датчикуудтай холбогдоно. Цахилгаан тэжээлийг UPS дамжуулан тэжээнэ. Инверьтер, АУС самбарууд, UPS -г КИП и А автоматикийн зургаас үз. Цахилгаан ачаалалын тооцоонд ажлын насосны хүчин чадлаар тооцож тооцооны коэффициент COS фи болон ашигт үйлийн коэффициентийг давхар тооцсон болно. Инверьтерээс гарч байгаа кабелийг эзс голтой экрантай кабелиар тусгасан болно.

Өрөөнд тавигдах төхөөрөмжүүд нь ус чийг, тоосноос хамгаалагдсан байх шаардлагатай.

Кабель шугам, самбар нь гал дэмждэггүй байх шаардлагатай. Давтамж хувиргагчаас гач байгаа кабелиудын ган хоолойд сүвлэн тэжээсэн да ган хоолойг газардуулгад холбоно.

Цахилгаан дамжуулах утас , кабелийг хана буюу хучилтанд пластмассан хоолойд сүвлэн ил ,барилгын ханаар кабелийн тавиур хийцээр тавина.

3.ГЭРЭЛТҮҮЛЭГ.

Гэрэлтүүлгийн ажлын , ослын , нүүлгэн шилжүүлжлтийн зориулалтаар төлөвлөж өрөөний нөхцлөөс хамааруулан сонгож авлаа.Нүүлгэн шилжүүлэлтийн гэрэлтүүлэгчийг хонгил, шатны талбайд " ГАРАХ" бичигтэй гэрэлтүүлэгчийг тоноглоно. Өрөөнд ослын цэнэг хуимтлуулагтай гэрэлтүүлэгч тоноглоно.Унтраалгыг шалнаас дээш 1,5м , розеткийг 0,3-1,2м тус тус тоноглоно.

4.ПОТЕНЦИАЛ ТЭГШИТГЭЛ.

1-р зэргийн хамгаалалтын ангилалд багтах цахилгаан төхөөрөмжүүдийн гүйдэл үл дамжуулах их биеийг тэглэх.Үүнд: ЕС самбарууд ын их бие, гэрэлтүүлэгчийн их бие ,цахилгаан дамжуулагч утас сүвлэх ган хоолой зэрэг болно.

Цахилгаан хэрэглэгчдийн их биеийг тэглэхдээ тухайн хэрэглэгчдийг тэжээсэн ЕС, самбарууд ад татсан хамгаалалтын газардуулгын тусгай дамжуулагч PE 3 фазын 400/230В хүчдэлтэй сүлжээний 5 дахь утас, 1 фазын -3 дахь утсыг тус, тус ашиглана.Розетко, гэрэлтүүлэгчийн төмөр их биеийг тэглэх 3 дах бие даасан дамжуулагчийг гагнах, тусгай хавчаар ашиглан холбоно.2-р зэргийн хамгаалалтын ангилалд багтах гэрэлтүүлэгчдийг сүлжээг 2- утаст буюу фазын болон ажлын тэг / N/ дамжуулагчуудаар гүйцэтгэнэ.

ХС самбарууд ын розетконы сүлжээний группэд хэт хүчдлээс хамгаалах -ХХТ дифференциаль автомат тоноглоно.Дараахи дамжуулах хэсгүүдийг хооронд нь холбож потегциал тэгшитгэх төв системийг гүйцэтгэнэ.

Хуваарилах болон гэрэлтүүлгийн шугамуудын хамгаалалтын тэг дамжуулагч / PE / кабелийн тавиур , газардуулгын хүрээнд холбогдсон газардуулгын дамжуулагч, барилгын инженерийн шугам сүлжээний ган хоолойнууд багтана.Агаар сэлгэлтийн төмөр хоолойг ХС самбарууд ын / PE/ шинд холбоно.Металл угаартуур, ванныг тусгай дамжуулагчаар PE шинд холбоно.

Барилгын инженерийн шугам сүлжээний оролтын төмөр хоолойнууд, барилгын төмөр хийцүүд, аянга хамгаалалт, газардуулгын төмөр хийц, хамгаалалтын тэг шин / PE/ дамжуулагч зэргийг хооронд нь холбосноор барилгын потегциал тэгшитгэх ситемийг бүрдүүлнэ.Оролтын болон хүчний самбарын ГЕШ газардуулгын ерөнхий шин -г давтан газардуулах да газардуулгын эсэргүүцэл 4 Ом-с ихгүй байна. Хэрвээ хэтэрсэн тохиолдолд нэмэлтээр газардуулгын электод зооно.

5.Аянга хамгаалалт

Аянга хамгаалалтын зураг төслийг БД43-103-08 барилга байгууламжийн аянга хамгаалалтын зураг төсөл зохиох зааварын дагуу инженер геологийн дүгнэлтээс хөрсний хувийн цахилгаан эсэргүүцлийг тооцож хийнэ.Аянга хүлээн авах торыг барилгын дээвэр дээр цайдсан бөөрөнхий ган ф-10мм тусгай хөндийрүүлэг дэрээр хөндийрүүлэн гүйцэтгэнэ.Уг торноос гүйдэл дамжуулагчийг 40*4мм цайдсан туузан төмрийг барилгын боломжтой ханаар 15-20 мм зайд барилгын гадна тоосгон ханаар ил явуулах тохиолдолд гал дэмждэггүй хоолойд сүвлэх да гал дэмдэггүй түрхлэг түрхэж хамгаалалт хийж явуулна.

Барилгын гадна газардуулгыг периметрийн дагуу хананаас 1м зайд -0,7м гүнд тавих цайдсан туузан төмөр 40*4мм -р гүйцэтгэнэ.Гүйдэл зайлуулагчтай холбох хэсэгт 3,0м урттай 50*50*5мм цайдсан булан төмрийг газрын хөрснөөс доош буюу хөлдөлтийн гүнээс доош буулан төмөр электроод зоож өгнө.

Барилгын суурийн арматуурыг газардуулагчтай 10мм бөөрөнхий ганг 5 м урттай холбоно.Бүх угсралтын цахилгаан гагнаасаар хийж гүйцэтгэнэ.Угсралтын мэрэгжлийн байгууллагаар хүчин төгөлдөр норм дүрмийг үндэслэн хийж гүйцэтгэнэ.

Таних тэмдэг

Дэс дугаар	Нэр	Таних тэмдэг
1	Ерөнхий болон хүчний хуваарилах самбар	
2	Тоног төхөөрөмжийн удирдлагын самбар	
3	Сэлгэн залгагч	
4	Автомат таслуур	
5	Дифференциаль автомат	
6	Бүрэн электрон тоолуур	Wh
7	лэд чийдэнтэй гадна гэрэлтүүлэгчийг тулц, барилгын ханан дээр бэхлэх	
8	лэд чийдэнтэй ослын цэнэг хуримтлуулагчтай гэрэлтүүлэгч	
9	Гарах бичигтэй лэд чийдэнтэй гэрэлтүүлэгч	ГАРАХ
10	лэд чийдэнтэй таазнаас зүүх хамгаалагдсан гэрэлтүүлэгч	
11	Ил тоноглох 2 туйлт хамгаалагдсан унтраалга	
12	Газардуулгын контакттай ил тавих 2 туйлт хамгаалагдсан тагтай розетк	
13	Цэнэг шавхагч ОПС1-В/4, ОПС1-С/4, ОПС1-D/2	
14	Дамжуулагч утас , кабель	
15	Ослын гэрэлтүүлгийн шугам	
16	Газардуулагчид гол шугамын газардуулга	
17	Дотор газардуулгын хүрээ цайрдсан туузан төмөр 25*4 мм	
18	Гадна газардуулгын хүрээ цайрдсан туузан төмөр 40*4 мм	
19	Аянга хамгаалах тор цайрдсан бөөрөнхий ган ф-10 мм	

Барилгын зураг төсөл	Говь-Алтай аймаг Есөнбулаг сум 3000м3/хоног хүчин чадалтай цэвэрлэх байгууламж. Бохир усны насос станцын барилга				
	Тайлбар бичиг , таних тэмдэг.				
"ЭЛСТА" ХХК УТАС: 70180532	Инженер	Ж.Амарсанаа	Е.Г шифр: НР-09/2022	Масштаб: М1:100	огноо : 2023 он
	Гүйцэтгэсэн	О.Гантуяа	Т.Г шифр: ЭЛ-23.2/2023	Зургийн дугаар ХТ-2	13
	Шалгасан	Ж.Амарсанаа			

А3

Тоног төхөөрөмжийн түүвэр

Д/Д	НЭР	МАЯГ	ширх	Тоо хэмж	ТАЙЛБАР
1	Ортолтын ерөнхий самбар. IP>54, 2000*1500*400мм хэмжээтэй. Автомат сэлгэн залгагч ATS , 50А-1ш Гүйдлийн трансформатор -ТТИ-30-25/5А-3ш Бүрэн элктрон тоолуур 380В,5А-1ш Вольтметр сэлгэн залгагчын хамт 0-500В-1ш Амперметр сэлгэн залгагчийн хамт 0-200А-1ш Хяналтын чийдэн ВА47-29-2Р-6А хар-ка D-1ш Оролтонд автомат ВА88-32-3Р-63А-1ш Шугаманд автомат ВА88-32-3Р-32А-2ш дифференциаль автомат АД12-2Р-16А-10мА-1ш ВА47-29-2Р-16А-1ш цэнэг шавхагч ОПС1-В4/1 комп	-	ком	1	ЕС1
2	ОСО-250 маягийн трансформатортой хайрцаг.250/36В		ш	1	
3	60Вт чадалтай лэд чийдэнтэй хананд тавих хамгаалагдсан тортой гэрэлтүүлэгч IP44	L1	ком	1	
4	2*8 чадалтай лэд чийдэнтэй хананд тавих хамгаалагдсан гэрэлтүүлэгч IP44 цэнэг хуримтуулагчтай	L2	ком	1	
5	1*8 чадалтай лэд чийдэнтэй хананд тавих хамгаалагдсан гэрэлтүүлэгч IP44 гарах бичигтэй ослын гэрэлтүүлэгч	L3	ком	1	ГАРАХ
6	1*100 чадалтай лэд чийдэнтэй таазнаас зүүх хамгаалагдсан гэрэлтүүлэгч IP44	L4	ком	1	
7	Хоёр туйлт хамгаалагдсан ил тавих унтраалга		ш	1	
8	Ил тавих газардуулгын контакттай 2туйлт шпепсель залгуур 250В,16А, IP54		ш	1	
9	Лэд чийдэнгийн шил 8Вт		ш	2	
10	Лэд чийдэнгийн шил 60Вт		ш	1	
11	Лэд чийдэнгийн шил 100Вт		ш	1	

Тоног төхөөрөмжийн түүвэр

Д/Д	НЭР	МАЯГ	ширх	Тоо хэмж	ТАЙЛБАР
12	Кабель салбарлах хайрцаг		ш	2	
13	3*2.5 мм2 хөндлөн огтлолтой зэс голтой кабель	ВВГ-660	м	30	
14	3*4 мм2 хөндлөн огтлолтой зэс голтой кабель	ВВГ-660	м	10	
15	5*10 мм2 хөндлөн огтлолтой зэс голтой кабель	ВВГ-660	м	5	
16	Гал дэмждэггүй хуванцар хоолой ф16		м	30	
17	Гал дэмждэггүй хуванцар хоолой ф32		м	5	
18	Зэс төгсгөвч	10mm2	ш	5	
19	Уян оруулга		ш	1	
20	Цайрдсан туузан ган	25*4мм	м	10	
21	Цайрдсан туузан ган	40*4мм	м	20	
22	Цайрдсан бөөрөнхий ган	ф-10мм	м	30	
23	Цайрдсан булан төмөр	50*50*5мм	ш	6	
24	Газардуулгын нэгдсэн самбар	ГЗС	ш	1	

Барилгын зураг төсөл "ЭЛСТА" ХХК УТАС: 70180532	Говь-Алтай аймаг Есөнбулаг сум 3000м3/хоног хүчин чадалтай цэвэрлэх байгууламж. Бохир усны насос станцын барилга				
	Материалын түүвэр.				
Инженер	Ж.Амарсанаа	Е.Г шифр:	Масштаб: М1:100	огноо : 2023 он.	
Гүйцэтгэсэн	О.Гантуяа	Т.Г шифр: ЭЛ-23.2/2023	Зургийн дугаар ХТ-3	13	
Шалгасан	Ж.Амарсанаа				

А3

Давхрын гэрэлтүүлэгт	Давхрын розетконд	Тоног төхөөрөмжийн удирдлагын самбар	нөөц

1 давхар



Тайлбар.

Группын шугам дээрхи бичлэгийн тэмдэглэгээ дэс дараалал.

Магистраль ба группийн шугам							
Шугамын тэмдэг-лэгээ	Тооцооны ачаалал кВт	Тооцооны гүйдэл А	Урт м	Момент кВт*м	Хүчдэлийн алдаглал %	Дамжуулагчийн тоо хөндлөн огтлол	Хоолой маяг диаметр

5-4
20 23.12.25

Барилгын зураг төсөл	Говь-Алтай аймаг Есөнбулаг сум 3000м3/хоног хүчин чадалтай цэвэрлэх байгууламж. Бохир усны насос станцын барилга					
"ЭЛСТА" ХХК УТАС: 70180532	Ерөнхий самбарынтооцооны бүдүүвч.					
	Инженер	Ж.Амарсанаа	Е.Г шифр: НР-09/2022	Масштаб: М1:100	огноо : 2023 он	
	Гүйцэтгэсэн	О.Гантуяа				
	Шалгасан	Ж.Амарсанаа	Т.Г шифр: ЭЛ-23.2/2023	Зургийн дугаар ХТ-4	12	

±0.00 ТҮВШНИЙ БАЙГУУЛАЛТ М1:50



ОГТЛОЛ 1-1 М1:50

Рубероид - 2 үе
Элс цементэн тэгшилгээ М50 -20 мм
Керамзит налуулга у=600 кг/м^3 -50-200 мм
Дулаалга /хөөсөнцөр хавтан-EPS/ -200 мм
g=24кг/м^3 λ=0.041вт/м°С, MNS EN-13163-2011
Уур тусгаарлагч 1 үе пергамин
Цементэн тэгшилгээ -20 мм
Цутгамал төмөр бетон хучилт -150 мм



-7.58 ТҮВШИНИЙ БАЙГУУЛАЛТ М1:50



ДЭЭВРИЙН БАЙГУУЛАЛТ М1:50



ӨРӨӨНИЙ ТОДОРХОЙЛОЛТ



Д/Д	Өрөөний нэр	Талбай м2	Гэрэлтүүлгийн хэмжээ/лк/
1	Засварын өрөө	4.00	30
2	Бохир ус хүлээн авах өрөө	4.00	30

Барилгын зураг төсөл

"ЭЛСТА" ХХК
УТАС: 70180532

Говь-Алтай аймаг Есөнбулаг сум 3000м3/хоног хүчин чадалтай цэвэрлэх байгууламж.
Бохир усны насос станцын барилга

Хучит төхөөрөмжийн байгуулалт .0.00

Инженер		Ж.Амарсанаа	Е.Г шифр: НР-09/2022	Масштаб: М1:100	огноо : 2023 он
Гүйцэтгэсэн		О.Гантуяа			
Шалгасан		Ж.Амарсанаа	Т.Г шифр: ЭЛ-23.2/2023	Зургийн дугаар ХТ-5	12

5-4
2023.12.25

A2

ОГТЛОЛ 2-2 М1:50

Рубероид - 2 үе
Элс цементэн тэгшилгээ М50 -20 мм
Керамзит налуулга у=600 кг/м^3 -50-200 мм
Дулаалга /хөөсөнцөр хавтан-EPS/ -200 мм
g=24кг/м^{3}λ=0.041вт/м°С, MNS EN-13163-2011
Уур тусгаарлагч 1 үе пергамин
Цементэн тэгшилгээ -20 мм
Цутгамал төмөр бетон хучилт -150 мм



НҮҮР ТАЛ /тэнхлэг 1-2/ М1:50



5-4
20 23.12.25

Барилгын зураг төсөл	Говь-Алтай аймаг Есөнбулаг сум 3000м3/хоног хүчин чадалтай цэвэрлэх байгууламж. Бохир усны насос станцын барилга				
	Огтлол 2-2.аянга хамгаалалт, газардуулга.				
"ЭЛСТА" ХХК УТАС: 70180532	Инженер	Ж.Амарсанаа	Е.Г шифр: НР-09/2022	Масштаб: М1:100	огноо : 2023 он
	Гүйцэтгэсэн	О.Гантуяа	Т.Г шифр: ЭЛ-23.2/2023	Зургийн дугаар ХТ-6	12
	Шалгасан	Ж.Амарсанаа			





№	Тайлбар
1	Ерөнхий оролтын самбар
2	Ерөнхий оролтын самбарын тэжээлийн кабель
3	Самбарын суурь
4	Дотор газардуулгын хүрээ 25х4мм-ийн туузан төмөр
5	Гадна газардуулгын хүрээ 40х4мм-ийн туузан төмөр
6	Босоо электрод е=3м цайрдсан булан төмөр 50*50*5мм
7	Самбарыг хананд бэхлэх байдал
8	Самбарыг дотор газардуулгын хүрээнд боолтоор холбох
9	Хөрсөнд босоо электрод байрлуулах байдал

Цэнэг шавхагч ашиглан хэт хүчдэлээс
хамгаалах бүдүүвч



Тайлбар

ОПС-1 хэт хүчдэлийн хязгаарлагч (цэнэг шавхагч) нь аянгын ниргэлтээс үүдэлтэй хүчдлийн өсөлт, 1 болон 2 фазын богино залгаа, 1 фазын газардуулга, газартай харьцангуй багтаамжаас үүдэлтэй хүчдэлийн ихсэлтийг газардуулах байгууламжруу шавхаж хэрэглэгч дээрхи хүчдэлийг шугамын зөвшөөрөгдөх алдагдалын хэмжээнд барихаар зориулагдсан төхөөрөмж.
Цохилтын гүйдлээс хамааруулан ОПС-1 (В, С, D) гэж ангилдаг.

" ЭЛСТА " ХХК	Говь-Алтай аймаг Есөнбулаг сум 3000м3/хоног хүчин чадалтай цэвэрлэх байгууламж. Бохир усны насос станцын барилга				
	Ерөнхий оролтын самбарыг дотор ба гадна газардуулгын хүрээнд холбох.				Ye шат: А.3
	Инженер	Ж.Амарсанаа	ЕГ Шифр: НР-09/2022	Масштаб: 1:100	Огноо: 2023 он
	Гүйцэтгэсэн	О.Гантуяа	ТГ Шифр: ЭЛ-23.2/2023	Зургийн дугаар: ХТ-7	Хуудас: 12
	Шалгасан	Ж.Амарсанаа			

А3



" ЭЛСТА " ХХК	Говь-Алтай аймаг Есөнбулаг сум 3000м3/хоног хүчин чадалтай цэвэрлэх байгууламж. Бохир усны насос станцын барилга				
	Аянга хамгаалалт, газардуулгын хэсэглэл.				Ye шат: А.3
	Инженер	Ж.Амарсанаа	ЕГ Шифр: НР-09/2022	Масштаб: 1:100	Огноо: 2023 он
	Гүйцэтгэсэн	О.Гантуяа			
	Шалгасан	Ж.Амарсанаа	ТГ Шифр: ЭЛ-23.2/2023	Зургийн дугаар: ХТ-8	Хуудас: 12

А3



Тайлбар

М- дамжуулах хэсэг

С1- барилга руу орсон цэвэр усны төмөр хоолой

С2- барилга руу орсон бохир усны төмөр хоолой

С3- барилга руу орсон оромжин хэсэгт тусгаарлагатай хийн хоолой

С4- агааржуулалт ба агаар сэлгэлтийн агаар дамжуулах хоолой

С5 хамгаалалтын систем

С6- ванны өрөөний цэвэр усны төмөр хоолой

С7 төмөр металл

С8- ил хэсгүүдийн хүрч болох хэсэг

С9- төмөр бетон бүтээцийн арматур

ГЗШ- ерөнхий газардуулгын шин

Т1- ердийн (байгалийн) газардуулагч
Т2- аянга хамгаалалтын буулт

1- Нойлын хамгаалалтын дамжуулагч
2- Потенциал тэгшитгэх үндсэн системийн дамжуулагч (утас)
3- Потенциал тэгшитгэх нэмэгдэл системийн дамжуулагч (утас)

4- Аянгын хамгаалалтын системийн гүйдэл дамжуулагч

5- Тооцоолон бодох, мэдээллийн төхөөрөмж байрлуулсан өрөөний ажлын газардуулгын хүрээ (контур)
6- Ажлын (тусгай үүргийн) газардуулгын дамжуулагч (утас)

7- Ажлын газардуулгын системийн потенциал тэгшитгэх дамжуулагч (утас)

8- Газардуулгын (утас) дамжуулагч



" ЭЛСТА " ХХК	Говь-Алтай аймаг Есөнбулаг сум 3000м3/хоног хүчин чадалтай цэвэрлэх байгууламж. Бохир усны насос станцын барилга				
	Барилгын потенциаль тэгшитгэх систем.				Үе шат: А.З
	Инженер	Ж.Амарсанаа	ЕГ Шифр: НР-09/2022	Масштаб: 1:100	Огноо: 2023 он
	Гүйцэтгэсэн	О.Гантуяа			
	Шалгасан	Ж.Амарсанаа	ТГ Шифр: ЭЛ-23.2/2023	Зургийн дугаар: ХТ-9	Хуудас: 12

А3



Тайлбар

Үн барилгын газардуулгын хэсгийн зураг төслийг барилга архитектурын байгуулалтыг үндэслэн БД43-103-08 болон бусад холбогдох норм дүрмийн дагуу гүйцэтгэв. Төсөлд газардуулгыг гүн газардуулсан нейтраль TN-C-S газардуулгын системээр хийв. Хуваарилах самбаруудад хамгаалалтын утас (PE) холбоход зориулсан болттой нэмэлт зэс шин угсарна. Газардуулгын дотор хүрээг 25*4мм-ийн зэс туузаар шалны түвшингээс 0,5мм өндөрт хананы дагуу зайгүй эсвэл далд хийж өгнө. Эсэргүүцэл хэмжих үүднээс газардуулгын ерөнхий шин (ГЕШ) дээр газардуулгын дамжуулагчийг салгах боломж бүрдүүлэх. Энэхүү салгалтыг зөвхөн багаж хэрэгслийн тусламжтайгаар гүйцэтгэхээр хийцэх ба механик талаас бат бөх ба цахилгаан хэлхээний тасралтгүй байдлыг хангасан байна.

1- Хамгаалалтын нойл утас, PE (кабелийн бүрэлдэхүүний 5 дахь утас)

2- Потенциаль тэгшитгэх системийн утас, ВВГ-1*25мм2 (шар ногоон)

" ЭЛСТА " ХХК	Говь-Алтай аймаг Есөнбулаг сум 3000м3/хоног хүчин чадалтай цэвэрлэх байгууламж. Бохир усны насос станцын барилга				Ye шат: А.3
	Потенциалийг тэгшитгэх болон газардуулгын системийн бүдүүвч				
	Инженер	Ж.Амарсанаа	ЕГ Шифр: НР-09/2022	Масштаб: 1:100	Огноо: 2023 он
	Гүйцэтгэсэн	О.Гантуяа			
	Шалгасан	Ж.Амарсанаа	ТГ Шифр: ЭЛ-23.2/2023	Зургийн дугаар: ХТ-10	Хуудас: 12

А3

АЯНГА ХАМГААЛАЛТ, ГАЗАРДУУЛГЫН ТООЦОО

Говь-Алтай аймаг Есөн булаг сум 3000м3/хоног Цэвэрлэх байгууламжийн Бохир усны насос станцын барилгын аянга хамгаалалт газардуулгын тооцоог хийхдээ инженер геологийн " ИНЖЕНЕР ГЕОДЕЗИ "-ийн 2022 оны архив №3Т11-132/22 тоот инженер геологийн дүгнэлтийн дагуу хийж гүйцэтгэв.

Цооногуудыг дунджилж тооцоо хийх боломжгүй байгаа тул цооног тус бүрдээр тооцоо хийж гарсан босоо электродын тоонуудыг дунджилж 6 электродоор тооцов.

Байгаль цаг уурын үзүүлэлт :

Хөрсний ерөнхий дүгнэлт:

- Элсэн чигжээстай хайрган ул хөрс ИГЭ- 1
- Элсэн чигжээстай хайрган хөрс ИГЭ- 2
- Хөрсний эсэргүүцэл: ИГЭ-1 P1 = =548 -597.6 Ом*м
- Хөрсний эсэргүүцэл: ИГЭ-2 P2 = 314-327 Ом*м

Устай үед

Гадна агаарын үнэмлэхүй хамгийн их температур +31.0 C°

Гадна агаарын үнэмлэхүй хамгийн бага температур -42.0 °C

Хөрсний усны түвшин (газрын түвшнээс доош) -2.6

Улирлын хөлдөлтийн гүн -3.37м

Газар чичирхийлэлийн зэрэг - 5 балл

Үндсэн өгөгдөл:

Цаг уурын бүс- III

Босоо электродын цаг уурын бүсчлэлээс хамаарах коэффициент 1.4-1.6 kб≈1.5

Хэвтээ электродын цаг уурын бүсчлэлээс хамаарах коэффициент 2.0-2.5 kx≈2.25

Босоо электрод 50x50x5 мм; Босоо электродын урт Lб=3м

Хэвтээ электрод 40x4мм

Инженер геологийн зүсэлт
II-II' шулуунаар



Цооногийн дугаар	Ц-4	Ц-5	Ц-6
Үнэмлэхүй өндөржилт (м)	2139.34	2139.29	2139.42
Цооног хоорондын зай (м)	35.95		

Тооцоо /Цооног-4/

Хөрсний дээд үеийн эсэргүүцэл Ом.м

$$\rho_{e1} = \frac{\sum_{i=1}^{k} h_i}{\sum_{i=1}^{k} \frac{h_i}{k_a * \rho_i}} = \frac{2.6+1.2}{\frac{2.6}{1.5*300}+\frac{1.2}{1.5*300}} = \frac{3.8}{\frac{3.8}{600}} = 300 \text{ Ом.м}$$

Хөрсний доод үеийн эсэргүүцэл Ом.м

$$\rho_{e2} = \frac{\prod_{i=k+1}^{n} h_i * \rho_i}{H_{тооц} + t + L_б} = \frac{1*300+1.2*400}{5*1.5+0.7+5} = \frac{560}{13.2} = 42.4$$

Хөрсний эквивалент эсэргүүцэл Ом.м

$$\rho_{эк} = \frac{\rho_{e1}*\rho_{e2}*L_б}{\rho_{e1}*(L_б-h_{эмл}+t)+\rho_{e2}*(h_{тооц}-t)} = \frac{300*97.0*5}{300*(5-3.8+0.7)+97.0*(3.8-0.7)} = \frac{116400}{456+300.7} = 153.5 \text{ Ом.м}$$

Булан төмрөөр хийсэн босоо электродын эсэргүүцэл Ом

$$R_o = \frac{0.366*\rho_{эк}}{L_b}\left(\lg\frac{2*L_b}{0.95*b} + \frac{1}{2}\lg\frac{4T+L_b}{4T-L_b}\right) = \frac{0.366*153.5}{5}\left(\lg\frac{2*5}{0.95*0.05} + 0.5*\lg\frac{4*3.2+5}{4*3.2-5}\right) =$$

$$=17.5*(\lg 210.5+0.5*\lg 2.28) = 17.5*(2.3+0.5*0.4) = 23.7 \text{ Ом.м}$$

Босоо электродын ашиглалтын коэффициент

$$\eta_б^{a} = \frac{a}{L} \text{ үед}$$

Босоо электродын тоо, ш

$$n_o^1 = \frac{R_o}{R_x * \eta_б} = \frac{23.7}{4*1} = 5.9ш$$

Босоо электродын ашиглалтын коэффициентыг хүснэгтээс авч интерполяц хийвэл

$$\eta_б^{1(10-20)} = 0.55 - \frac{0.55-0.47}{10} * 0.9 = 0.5428 \qquad n_o^1 = \frac{23.7}{4*0.5428} = 11.1ш$$

$$\eta_б^{2(20-40)} = 0.47 - \frac{0.47-0.41}{20} * 0.1 = 0.4697 \qquad n_o^2 = \frac{23.7}{4*0.4697} = 13.2ш$$

$$\eta_б^{3(20-40)} = 0.47 - \frac{0.47-0.41}{20} * 3.2 = 0.4604 \qquad n_o^3 = \frac{23.7}{4*0.4604} = 13.7ш$$

$n_o = n_o - n_o^2 = 13.2-13.7 = 0.5$ $n_o \leq 1$ байна.

Хэвтээ электродын урт, м

$L_x = a*(n-1) = 5*(14-1) = 65м$; Ажлын зургаар L_x=30м байгаа тул тооцоонд 30м-ээр авав.

Хэвтээ электродын ашиглалтын коэффициент

$$\eta_x^{(20-30)} = 0.27 - \frac{0.27-0.24}{10} * 3.7 = 0.2589$$

Хэвтээ электродын газардуулагчийн эсэргүүцэл, Ом

$$R_x = 0.366* \left(\frac{\rho_1 * k_x}{L_x * \eta_б}\right) * \lg\left(\frac{2*L_x^2}{b*t}\right) = 0.366* \left(\frac{300*2.25}{136*0.2589}\right) * \lg\left(\frac{2*136^2}{0.04*0.7}\right) =$$

$$= 0.366*51.1*\lg 1321143 = 18.7*6.1 = 44.1 \text{ Ом}$$

Газардуулгийн эсэргүүцэл, $R_г$<4 Ом байна.

$$R_г = \frac{R_б * R_x}{R_б * \eta_x + R_x * n_o * \eta_б} = \frac{23.7*44.1}{23.7*0.2589 + 44.1*24*0.4604} = \frac{1045.1}{6.3+486} = 2.1 \text{ Ом.м}$$

" ЭЛСТА " ХХК	Говь-Алтай аймаг Есөнбулаг сум 3000м3/хоног хүчин чадалтай цэвэрлэх байгууламж. Бохир усны насос станцын барилга					
	Потенциалийг тэгшитгэх болон газардуулгын системийн бүдүүвч					Үе шат: А.З
	Инженер		Ж.Амарсанаа	ЕГ Шифр: НР-09/2022	Масштаб: 1:100	Огноо: 2023 он
	Гүйцэтгэсэн		О.Гантуяа			
	Шалгасан		Ж.Амарсанаа	ТГ Шифр: ЭЛ-23.2/2023	Зургийн дугаар: ХТ-11	Хуудас: 12

А3

ГЭРЭЛТҮҮЛЭГЧИЙН МАЯГ .

L1 Лэд чийдэнтэй хамгаалагдсан гэрэлтүүлэгч	L2 Лэд чийдэнтэй хамгаалагдсан гэрэлтүүлэгч ГАРАХ	L3 Лэд чийдэнтэй цэнэг хуримтлуулагчтай гэрэлтүүлэгч	L4 Лэд чийдэнтэй таазнаас зүүх гэрэлтүүлэгч
	ГАРАХ		
Лэд чийдэнтэй гэрэлтүүлэгч	Лэд чийдэнтэй гэрэлтүүлэгч	Лэд чийдэнтэй гэрэлтүүлэгч	Лэд чийдэнтэй гэрэлтүүлэгч
Хананд тоноглох	Хананд тоноглох	Хананд тоноглох	Таазнаас зүүх
Хүчин чадал 1х60Вт	Хүчин чадал 1х8Вт	Хүчин чадал 2х8Вт	Хүчин чадал 1х60Вт
Хамгаалагт IP44	Хамгаалагт IP44	Хамгаалагт IP44 Цэнэглэгддэг	Хамгаалагт IP20

ТАНИХ ТЭМДЭГ .

Д/Д NO.	ТАНИХ ТЭМДЭГ	НЭР	ҮГСРАЛТ	ЧИЙДЭН	ХҮЧДЭЛ	ХАМГААЛАЛТ ЗЭРЭГ	ТАЙЛБАР
L1		Лэд чийдэнтэй гадна хананд тавих хамгаалагдсан гэрэлтүүлэгч	гадна тавих	1х60Вт	250В	IP44	
L2	ГАРАХ	Лэд чийдэнтэй гарах бичигтэй гэрэлтүүлэгч	Хананд тавих	1х8Вт	250В	IP44	
L3		Лэд чийдэнтэй цэнэг хуримтлуулагчтай гэрэлтүүлэгч	Хананд тавих	2х8Вт	250В	IP44	
L4		Лэд чийдэнтэй таазнаас зүүх гэрэлтүүлэгч	Таазнаас зүүх	100Вт	250В	IP44	

Д/Д №	ТАНИХ ТЭМДЭГ	НЭР	ҮГСРАЛТ	ГҮЙДЭЛ	ХҮЧДЭЛ	ХАМГААЛАЛТ ЗЭРЭГ	ТАЙЛБАР
R1		ИЛ ТОНОГЛОХ ГАЗАРДУУЛГЫН КОНТАКТТАЙ РОЗЕТК	ХАНАНД 300мм	16А	250В	IP44	
U1		ХОЁР ТҮЙЛТ ХАМГААЛАГДСАН УНТРААЛГА	ХАНАНД 1500мм	10А	250В	IP44	

Барилгын зураг төсөл	Говь-Алтай аймаг Есөнбулаг сум 3000м3/хоног хүчин чадалтай цэвэрлэх байгууламж. Бохир усны насос станцын барилга				
"ЭЛСТА" ХХК УТАС: 70180532	Таних тэмдэг ,гэрэлтүүлэгчийн маяг.				
	Инженер	Ж.Амарсанаа	Е.Г шифр: НР-09/2022	Масштаб: М1 : 100	Огноо: 2023 он
	Гүйцэтгэсэн	О.Гантуяа	Т.Г шифр: ЭЛ-23.2/2023	Зургийн дугаар: ХТ-12	12
	Шалгасан	Ж.Амарсанаа			

А3

ХД маркийн үндсэн иж бүрэн ажлын зургийн жагсаалт

Дэс дугаар	Зургийн нэр	Хуудасны марк
1	Иж бүрэн зургийн жагсаалт, тайлбар	ХД-1
2	Материалын түүвэр, томъёолсон тэмдэг	ХД-2
3	Угсралтын бүдүүвч	ХД-3
4	Мэдээлэл дамжуулах шилэн кабелийн тархалтын схем	ХД-4
5	±0.00 түвшний холбоо дохиоллын байгуулалт	ХД-5

I.Тайлбар

Говь-Алтай аймаг Есөнбулаг сум 3000м3/хоног хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийн 9 дугаартай Дренажийн насос станцын барилгын дотор холбоо дохиоллын ажлын зургийг төлөвлөлт, байгуулалтын дагуу зохих норм дүрмийг үндэслэн хийж гүйцэтгэв. Үүнд:

-Барилга байгууламжийн мэдээлэл , холбоо, дохиоллын ажлын зураг боловсруулах MNS 6586:2016

-Барилга байгууламжийн гал унтраах төхөөрөмж, дохиоллын хэрэгсэл БНБД-21-04-05

-Мэдээлэл, холбоо, дохиоллын тоног төхөөрөмжийн тэмдэглэгээ MNS5532:2022

-Барилга, орон сууц, гудамж талбайд тавих хяналтын камер. Ерөнхий шаардлага. MNS6423:2013

- Орон сууцны барилгын мэдээлэл, холбооны суурин сүлжээний төлөвлөлт. MNS6580:2016
- Барилгын дотор холбоо дохиоллын суваг члал да кабелийн угсралт хийх. MNS 5471:2005

/ДБХЯ-ны сайдын 1995 оны 5-р сарын 10-ны өдрийн 127-р тушаал/.

Энэхүү барилга нь 2.2х2.2м хэмжээтэй барилга болно.

II.Зураг тусгасан үндсэн шийдэл.

1. Цэвэрлэх байгууламжийн цогцолбор нь
   - Механик цэвэрлэгээний барилга
   - Биологи цэвэрлэгээний блок
   - Захиргаа аж ахуйн, үйлдвэрийн барилга
   - Лагийн талбай
   - Элсний талбай
   - Дренажийн насос станцын барилга
   - Харуулын байр
   - Дэд өртөө гэсэн барилгуудаас бүрдэнэ.
2. Барилгууд хооронд мэдээлэл солилцох зорилгоор газар доогуур Ф63мм хуванцар хоолой, жижиг оролтын худаг бүхий суваг члалыг төлөвлөнө. Холбооны суваг члалаар 8 шөрмөс бүхий суваг члалын шилэн кабелийг суурилуулж шилэн кабелийн төгсгөлийн төхөөрөмжүүдийг цагираг сүлжээгээр холбож мэдээллийн тасралтгүй дамжуулах техникийн боломжийг бүрдүүлэв.
3. Мэдээлэл дамжуулах төхөөрөмж нь MOXA брэндийн 2 оптик, 6ш этернэт (ethernet) портуудтай шилэн кабелийн менажед (managed) төгсгөлийн төхөөрөмжийг суурилуулахаар төлөвлөв. Уг төхөөрөмжийн 1,2,3,4,5,6 этернэт портуудыг тус тусад нь VLAN суваг /ACCESS хэрэглэгч/ үүсгэн тохируулж, 1-р портоор IP телефоны, 2-р портоор зарлан мэдээлэх, 3-р портоор кабелийн телевизийн, 4-р портоор компьютерын сүлжээний, 5-р портоор хяналтын камерын, 6-р портоор галын дохиоллын мэдээллийн системийн урсгалыг дамжуулахаар төлөвлөв. Цэвэрлэх байгууламжийн цогцолборт мэдээллийн сүлжээ үүсгэх шаардлагатай 8 байршлуудад суурилуулахаар төлөвлөгдсөн MOXA брэндийн шилэн кабелийн төгсгөлийн төхөөрөмжүүдийн 2ш оптик /Trunk хэрэглэгч/ портуудыг /7,8-р порт/ "Turbo ring V2" протоколоор мэдээлэл дамжуулахаар тохиргоог хийнэ.
4. Бүх угсралтын ажлыг 16 мм-н уян хоолойд сүвлэнэ. Хананы розетка нь цахилгааны розеткаас 30 см багагүй, доод шалнаас 30 см-ийн зайд суурилуулна. Угсралтын хоолой, угсралтын хайрцгийг шал, хананы доогуур далд угсрана.

III. Кабелийн холболт.

1. 6 дугаартай бордооны хүлэмжийн барилга, 2 дугаартай биологийн цэвэрлэгээний барилгаас оролтын жижиг худгаар дамжин Ф63мм-н хуванцар хоолойгоор сүвлэгдэн ирэх 8 шөрмөстэй шилэн кабелийг дренажийн насос станцын барилгын хананы холболт хайрцагт байрлах 2ш шилэн кабелийн төгсгөлийн хайрцагт /FDF/ тус тус цэнэглэнэ.

IV. Телефоны сүлжээ

1. Дренажийн насос станцын барилгад IP телефоны розетка төлөвлөв. Дренажийн насос станцын барилгад техникийн засварын болон үзлэг үйлчилгээ хийх үеэр IP телефон аппаратуыг ашиглан цэвэрлэх байгууламжийн цогцолбрын дурын телефон хэрэглэгч луу дуудлага хийх боломжтой байна.
2. IP телефон нь MOXA брэндийн шилэн кабелийн төгсгөлүүн төхөөрөмжийн 1-р портоор /VLAN1/ дамжин захиргаа аж ахуйн барилгын IP автомат телефон станцтай холбогдоно.

V. Галын дохиоллын систем

Ажлын зураг тусгасны дагуу галын дохиолол хүлээн авах төхөөрөмжийг Дренажийн насос станцын барилгын доод шалнаас 1.5 өндөрт суурилуулахаар төлөвлөв. Галын утаа мэдрэгчийг таазанд байрлуулан ZR-DJVVR1x2x1.0 мм маягийн галд тэсвэртэй утсаар Ф16 мм-ийн уян хоолойд сүвлэн холбоно. Галын гар мэдээлэгчийг доод шалнаас 1.5 м, дуут дохио өгөгчийг доод шалнаас 2.5 метрийн өндөрт хананд ил байрлуулан ZR-DJVVR1x2x1.0 мм маягийн утсаар холбоно.

Галын дохиоллын сүлжээг MOXA брэндийн шилэн кабелийн төгсгөлийн төхөөрөмжийн 6-р портоор/VLAN6/ дамжуулан цэвэрлэх байгууламжийн бусад барилгуудын галын дохиоллын нэгдмэл байдлыг хангана ажиллана.

VI. Зарлан мэдээллийн систем

Байнгийн хүн суухгүй тул зарлан мэдээлэх системийг төлөвлөөгүй болно.

VII. Хяналтын камерын систем

Дренажийн насос станцын барилгад IP технологи бүхий 1 ш ажиглалтын дуранг төлөвлөв. Хяналтын камерын системийн сүлжээ нь MOXA брэндийн шилэн кабелийн төгсгөлийн төхөөрөмжийн 5-р портоор /VLAN5/ дамжин захиргаа аж ахуйн барилгын холбооны раканд байрлах дүрс хянах, бичих, хадгалах төхөөрөмжтэй /NVR/ холбогдоно.

VIII. Угсралтын үед тавигдах шаардлага.

Угсралтын ажлыг холбоо дохиоллын системийн угсралтын ажлыг гүйцэтгэх тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагаар зургийн дагуу Монгол улсад мөрдөгдөж байгаа норм, дүрэм, стандарт, технологийн шаардлага болон үйлдвэрлэгчийн тоног төхөөрөмжийн угсралтын заавыг баримтлан хийж гүйцэтгэнэ.

Угсралтын ажлын явцад ажиллагсдын аюулгүй байдлыг хангахын тулд Монгол улсын хэмжээнд мөрдөгдөж байгаа аюулгүй ажиллагааны дүрмийн шаардлагыг ханган ажиллах шаардлагатай. Төлөвлөгдөж байгаа тоног төхөөрөмж, ажиллагсдын аюулгүй байдлыг хангахын тулд холбооны өрөөний шүүгээ(rack), техник хэрэгслийн металл их биеийг газардуулгын хүрээнд гагнаж холбоно. Газардуулгын эсэргүүцэл 4.0 Омоос хэтрэхгүй байна.

Барилгын Зураг Төслийн "УЛААН ТОЛГОЙ ХАЙРХАН" ХХК design & consulting	Говь-Алтай аймаг Есөнбулаг сумын эхний ээлжийн 3000м3/хоног хүчин чадалтай цэвэрлэх байгууламж. 9 дугаартай дренажийн насос станцын барилга				
	Иж бүрэн зургийн жагсаалт, тайлбар				
Инженер	Д.Нацагдорж		ЕГ шифр: НР-09/2022	Масштаб: -	Огноо: 2023-05
Гүйцэтгэсэн	Л.Шинэцэцэг		ТГ шифр: УТХ-08/2022	Зургийн дугаар: ХД-1	Хуудас: 5
Шалгасан	Д.Нацагдорж				

Томъёолсон тэмдэг

Нэр	Тэмдэглэгээ
Хананд далд суурилуулах телефон, компьютерын сүлжээ, кабелийн телевизийн хосолсон үүр	
Шаланд далд суурилуулах телефон, компьютерын сүлжээ, кабелийн телевизийн хосолсон үүр	
Хананд далд суурилуулах телефон, компьютерын сүлжээний хосолсон үүр	
Хананд суурилуулах кабелийн телевизийн үүр	
Холболтын хайрцаг, хэмжээ	
Тайзанд далд суурилуулах нимгэн ханатай угсралтын уян хоолой	E Ф16мм,ПВХ
Шал, хананд далд суурилуулах нимгэн ханатай угсралтын уян хоолой	A,B,C,E Ф16мм,ПВХ
Цахилгаан тэжээлийн шулуутгагч, хүчдэл баригч	
Кабелийн телевизийн оптик хүлээн авагч	
Кабелийн телевизийн салаалагч, чиглэлийн тоо	6 way
Кабелийн телевизийн өсгөгч	
Ажиглалтын дохиоллыг хүлээн авах станц	NVR
Барилгын гадаа суурилуулах цаг уурын нөхцлөөс хамгаалагдсан хөдөлгөөний хяналтын камер	WP Дуран
Барилгын дотор суурилуулах хөдөлгөөний хяналтын камер	Дуран
Хяналтын камерын ажиглалтын дэлгэц	32"
Галын дохиоллын гар мэдээлэгч	F
Галын дохиоллын дуут дохио өгөгч	
Галын утаа мэдрэгч	S
Галын дулаан мэдрэгч	H
Галын дохиолол хүлээн авах төхөөрөмж	FACP
Универсаль салаалах хайрцаг	
Батерей	Bat
Таазанд далд суурилуулах чанга яригч	
Зарлан мэдээлэх системийн өсгөгч	AMP
Бус сонгох товчлууртай пэйжинг микрофон	
Компьютерийн сүлжээний сэлгэгч төхөөрөмж свич /switch/	SW
Компьютерийн сүлжээний замчлагч төхөөрөмж роутер /router/	RT
Шилэн кабелийн хувиргагч төхөөрөмж /Media converter/	MCo
Шилэн кабелийн төгсгөлийн төхөөрөмж /Fiber optic termination /	FDF

Материалын түүвэр

Дэс дугаар	Нэр	Маяг	Тэмдэг-лэгээ	Хэмжих нэгж	Тоо	Тайлбар
	Хотын телефон					
1	IP телефоны хананы дан розетка	Модем хананы		ш	1	
2	IP телефон аппарат	KX-NT511	-	ш	1	
3	Компьютерын сүлжээний сэлгэгч төхөөрөмж	Switch PoE,5 порт	SW,PoE	ш	1	
4	Гадна суурилуулах зориулалттай сүлжээний кабель	CaT6E STP4x2x0.5мм	B	м	10	
5	Пластмассан нимгэн ханатай уян яндан	Ф16мм	B Ф16	м	8	
	Компьютерын сүлжээ					
6	Шилэн кабелийн хувиргагч /Media converter/	EDS508A--SS-SC	MOXA	Хос	1	
7	Тэжээлийн блок	NDR-240-48 127x123x63	PS	ш	1	MOXA төхөөрөмжийг тэжээнэ
8	Шилэн кабелийн төгсгөлийн хайрцаг	8 port 1U,19",SC	FDF	ш	2	
9	Шилэн кабелийн жампер кабель	SC-SC 3м, SM	-	ш	4	
	Хяналтын камер					
10	Барилгын дотор суурилуулах хөдөлгөөний хяналтын дуран	3 megapixel-с багагүй, PoE		ш	1	
11	Компьютерын сүлжээний сэлгэгч төхөөрөмж	Switch PoE,5 порт	SW,PoE	ш	1	
12	Дотор суурилуулах зориулалттай сүлжээний кабель	Indoor,CaT6E UTP4x2x0.5мм	B	м	10	
13	Пластмассан нимгэн ханатай уян яндан	Ф16мм	B Ф16	м	8	
	Галын дохиоллын систем					
14	Галын дохиолол хүлээн авах станц (Мэдээлэл солилцох ETHERNET порттой байх)	300x210x91	FACP	ш	1	Зах-иүн хүсэлтээр маягийг сонгоно
15	Дулаан мэдрэх хэт улаан туяаны үүсгэгчтэй галын дохиоллын мэдээлэгч, суурины хамт	-	H	ш	1	Зах-иүн хүсэлтээр маягийг сонгоно
16	85 dB хүртэл авиа үүсгэх чадалтай түгшүүрийн дуут дохио өгөгч	80dB		ш	1	Зах-иүн хүсэлтээр маягийг сонгоно
17	Гараар удирдах галын дохиоллын мэдээлэгч	-	F	ш	1	Зах-иүн хүсэлтээр маягийг сонгоно
18	Галын дохиоллын кабель	ZR-DJVVR 1x2x1.0мм	E	м	20	Галд тэсвэртэй кабель
19	Пластмассан нимгэн ханатай уян хоолой	Ф16мм	E Ф16	м	15	
	Бусад					
20	Холболтын хайрцаг	WxHxD 500x500x400		ш	1	
21	Хүчдэл баригч APC смарт	2.5 кВт	UPS	ш	1	
22	Олон залгуур /8 way socket PDU/	8 порт 1U,19"	PDU	ш	1	Ёвро стандарт
23	Газардуулгын утас	3эс, 6мм2	-	м	5	Холбооны шүүгээг газардуулах

Барилгын Зураг Теслийн "УЛААН ТОЛГОЙ ХАЙРХАН" ХХК design & consulting

Говь-Алтай аймаг Есөнбулаг сумын эхний эзлжийн 3000м3/хоног хүчин чадалтай цэвэрлэх байгууламж. 9 дугаартай дренажийн насос станцын барилга

Материалын түүвэр, томъёолсон тэмдэг

Инженер	Д.Нацагдорж		ЕГ шифр: НР-09/2022	Масштаб: -	Огноо: 2023-05
Гүйцэтгэсэн	Л.Шинэцэцэг		ТГ шифр: УТХ-08/2022	Зургийн дугаар: ХД-2	Хуудас: 5
Шалгасан	Д.Нацагдорж				

A2

Угсралтын бүдүүвч



Кабелийн тэмдэглэгээ

Таних тэмдэг	Кабелийн марк	Зорилуулалт
B	AMP Cat.6 UTP Cable, UTP4x2x0.5мм /Indoor cable/	Компьютер болон камерын сүлжээ /Дотор суурилуулах зориулалттай/
B'	AMP Cat.6 UTP Cable, UTP4x2x0.5мм /Outdoor cable/	Компьютер болон камерын сүлжээ /Гадна суурилуулах зориулалттай/
FO	Шилэн кабель,8C,SM,G652D	Барилга хооронд сувагчлалаар суурилуулна
E	1x2x1.0мм /Галд тэсвэртэй кабель/	Галын дохиоллын сүлжээ болон зарлан мэдээлэх системд ашиглана
J	Жампер кабель /SC-SC, SM, 3м/	-
AC	Тэжээлийн кабель. 2x1.5мм2	-

ГАЛ ТҮЙМРИЙН УЛСЫН ХЯНАЛТ БАТААГЧ 040

Барилгын Зураг Төслийн "УЛААН ТОЛГОЙ ХАЙРХАН" ХХК design & consulting	Говь-Алтай аймаг Есөнбулаг сумын эхний ээлжийн 3000м3/хоног хүчин чадалтай цэвэрлэх байгууламж. 9 дугаартай дренажийн насос станцын барилга				
	Угсралтын бүдүүвч				
	Инженер	Д.Нацагдорж	ЕГ шифр: НР-09/2022	Масштаб: -	Огноо: 2023-05
	Гүйцэтгэсэн	Л.Шинэцэцэг			
	Шалгасан	Д.Нацагдорж	ТГ шифр: УТХ-08/2022	Зургийн дугаар: ХД-3	Хуудас: 5

A2

Мэдээлэл дамжуулах шилэн кабелийн тархалтын схем



Мэдээллийн урсгалын төлөвлөлт:



Таних тэмдэг:

ШХ-10 — Төлөвлөгдөж байгаа холбооны жижиг худаг, хүдгийн дугаар

FDF,8C — Төлөвлөгдөж байгаа шилэн кабелийн төгсгөлийн хайрцаг, портын тоо

MOXA — Шилэн кабелийн хувиргагч /MOXA/EDS508A-SS-SC/ 2 оптик, 6 LAN-н порттой.

FO/8/7/23 (d) — Төлөвлөгдөж байгаа шилэн кабель, корын тоо, урт, он /d - сувагчлалаар/

Кабелийн тэмдэглэгээ

Таних тэмдэг	Кабелийн марк	Зориулалт
Ⓑ	AMP Cat.6 UTP Cable, UTP4x2x0.5мм /Indoor cable/	Компьютер болон камерын сүлжээ /Дотор суурилуулах зориулалттай/
FO	Шилэн кабель,8C,SM,G652D	Барилга хооронд сувагчлалаар суурилуулна
Ⓙ	Жампер кабель /SC-SC, SM, 3м/	-

Барилгын Зураг Төслийн "УЛААН ТОЛГОЙ ХАЙРХАН" ХХК design & consulting	Говь-Алтай аймаг Есөнбулаг сумын эхний ээлжийн 3000м3/хоног хүчин чадалтай цэвэрлэх байгууламж. 9 дугаартай дренажийн насос станцын барилга				
	Мэдээлэл дамжуулах шилэн кабелийн тархалтын схем				
	Инженер	Д.Нацагдорж		Масштаб: -	Огноо: 2023-05
	Гүйцэтгэсэн	Л.Шинэцэцэг	ТГ шифр: УТХ-08/2022	Зургийн дугаар: ХД-4	Хуудас: 5
	Шалгасан	Д.Нацагдорж			

A2

±0.00 ТҮВШНИЙ ХОЛБОО ДОХИОЛЛЫН БАЙГУУЛАЛТ М1:50



БАЙРШЛЫН ТОЙМ:



ТОДОРХОЙЛОЛТ:

1. Механик цэвэрлэгээний барилга
2. Биологи цэвэрлэгээний барилга I
3. Биологи цэвэрлэгээний барилга II
4. Үйлдвэрийн барилга
5. Захиргаа аж ахуйн барилга
6. Бордооны хүлэмжийн барилга
7. Лагын талбай
8. Элсний талбай
9. Дренажийн усны насос станц.
10. Дренажийн усны насос станц.
11. Харуулын байр.
12. Дэд өртөөний барилга.
13. Цугларах талбай.
14. Хог цуглуулах талбай.

ӨРӨӨНИЙ ТОДОРХОЙЛОЛТ

Д/Д	Өрөөний нэр	Талбай м2	Шалны төрөл
1	Засварын өрөө	4.00	Керамик хавтан
2	Бохир ус хүлээн авах өрөө	4.00	Fiber reinforced plastic 4 ує давхарлана

Зөвшөөрөлцсөн		
БА	Инженер О.Сүвд-Эрдэнэ	
ББ	Инженер Т.Хосзул	
ХАС, ЦБУ	Инженер О.Мөнхцэцэг	
ХТ, ДГ	Инженер О.Гэрэлээ	
ТХ	Инженер Ц. Чимидхорол	

Барилгын Зураг Теслийн "УЛААН ТОЛГОЙ ХАЙРХАН" ХХК design & consulting

Говь-Алтай аймаг Есөнбулаг сумын эхний ээлжийн 3000м3/хоног хүчин чадалтай цэвэрлэх байгууламж, 9 дугаартай дренажийн насос станцын барилга

±0.00 түвшний холбоо дохиоллын байгуулалт

Инженер	Д.Нацагдорж		ЕГ шифр: НР-09/2022	Масштаб: 1:100	Огноо: 2023-05
Гүйцэтгэсэн	Л.Шинэцэцэг		ТГ шифр: УТХ-08/2022	Зургийн дугаар: ХД-5	Хуудас: 5
Шалгасан	Д.Нацагдорж				

A2